Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.05.16

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 16

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Өнгөрсөн 7 хоногт алтны ханш 3.83%-иар уналаа. Ам.долларын ханш чангарч байгаа нь алтны ханшийг унагах гол шалтгаан болж байгаа юм.

Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг хурдацтай өсгөж, ам.долларын ханш чангарч байгаа нь алтны үнийг буулгаж байна.

Энэ нь хөрөнгө оруулагчдад ямар ч хүүгүй алтнаас илүүтэй өндөр хүүтэй бондод нь хөрөнгө оруулахад хүргэж байна.

АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн дарга Жером Пауэлл пүрэв гарагт хэлэхдээ тогтвортой үнэ нь эдийн засгийн үндэс тул инфляцийг хянах тэмцэл нь бага зэргийн таагүй зүйлсийг дагуулж магадгүй хэмээжээ.

АНУ нь Ковид-19 тахлын үед эдийн засгаа дэмжихийн тулд мөнгөний түрэмгий бодлого хэрэгжүүлснийн дараа ХНС гуравдугаар сард бодлогын хүүг дөрөвний нэг хувиар нэмэхийг зөвшөөрсөн юм. Үүнийг зарим шинжээч, бодлого боловсруулагчид үнийн өсөлтийг огцом бууруулах биш, зогсоохын тулд хэт хоцорсон шийдвэр гэж үзэж байна.

Алтыг инфляцийн өсөлт, зах зээлийн тодорхойгүй байдлаас хамгаалах хэрэгсэл гэж үздэг ч хүү нэмэгдэж байгаа нь хүүгүй активыг эзэмших зардлыг нэмэгдүүлж байна. Тиймээс алтанд хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5 сарын 16

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Хоёр сарын өмнө Олон улсын эрчим хүчний агентлаг /ОУЭА/-аас дэлхийн түүхий нефтийн нийлүүлэлт тасалдаж болзошгүй байгаа талаар түгшүүр зарласан. Тодруулбал, барууны орнууд ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээ авснаар дэлхийн нефтийн зах зээлээс өдөрт 3 сая баррель нефть арилна гэж таамагласан юм.

Гэтэл бодит байдал дээр нефтийн эдийн засагтай орнуудын эрэлт саарч, олборлолтын өсөлт нэмэгдэж байгаа нь богино хугацаанд зах зээлд нийлүүлэлтийн илүүдэл үүсгэх төлөвтай байна.

ОУЭА эрэлт удаашрах нь ОХУ-ын бойкотын үр дагаврыг даван туулахад туслах нь гарцаагүй гэж тайландаа онцолжээ. Тус агентлагийн мэдээлснээр, дэлхийн түүхий нефтийн эрэлт нефтийн үнийн өсөлтөөс болж оны эхний улиралд 4.4 сая байсан бол энэ улиралд 1.9 сая баррель болтлоо буурсан. Хоёрдугаар хагаст энэ өсөлт 490,000 баррель болтлоо огцом буурна хэмээн таамаглажээ.

Хэрэв ийм зүйл тохиолдвол Оросын үйлдвэрлэлийн алдагдлыг нөхөхөд маш их тус болно. Гэхдээ энэ нь БНХАУ-ын хөл хорионоос ихээхэн шалтгаална гэж шинжээчид үзэж байна.

3 сард ОПЕК нь ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнээс үүдсэн нийлүүлэлтийн хомсдолыг нөхөхгүй гэж хэлсэн бол дэлхийн өөр нэг томоохон үйлдвэрлэгч орон Бразил Оросын нийлүүлэлтийн цоорхойг нөхөхүйцээр үйлдвэрлэлээ хурдан нэмж чадахгүй гэдгээ мэдэгдэв.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*